

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

ХОТЫН СТАНДАРТ, ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ, БАЙГАЛЬ ОРЧИН ХАРИУЦСАН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН Б.ЭРДЭНЭЗУЛЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д                                                                                                                                                                                                                                                                                            | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                                                                                                              | Шалгуур үзүүлэлт                                                                    | Гүйцэтгэлийн түвшин                                                                  |                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                          | Биелэлтийн хувь |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----------------|
|                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                               |                                                                                     | Суурь түвшин                                                                         | Хүрэх түвшин                                                                 | Хүрсэн түвшин (биелэлт)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Эхэлсэн, дууссан хугацаа |                 |
|                                                                                                                                                                                                                                                                                                | 1                                                                                                                                                                                                                                             | 2                                                                                   | 3                                                                                    | 4                                                                            | 5                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 6                        | 7               |
| Стратегийн төлөвлөгөөний зорилго 1. "Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ."                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                               |                                                                                     |                                                                                      |                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                          |                 |
| Зорилт 1: Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглах хууль тогтоомж, хөрс, орчны бохирдол, доройтлыг бууруулах, хог, хаягдлын менежментийг сайжруулах талаар төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах. |                                                                                                                                                                                                                                               |                                                                                     |                                                                                      |                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                          |                 |
| 1.                                                                                                                                                                                                                                                                                             | Арга хэмжээ 1.1.<br>Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br>2025.04.01-2025.12.01 | Нөлөөллийн арга хэмжээ, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, тоо | 2024 оны байдлаар 1828 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж байна. | 1900 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон байна. | 2025 оны 05 дугаар сарын 4-7-ны өдрүүдэд Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас зохион байгуулсан "Дулаан байшин" аяны нээлттэй өдөрлөгт дүүргийн гэр хорооллын 15 хорооны 680 иргэдийг хамруулж, байгальд ээлтэй стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн дэвшилтэт технологийг танилцуулж ажилласан. Дүүргийн хэмжээнд стандартын шаардлага хангасан ариун цэврийн | 2025.04.01<br>2025.12.01 | 100             |

|    |                                                                                                                             |                                                                        |                                                                                                |                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                          |     |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|
|    |                                                                                                                             |                                                                        |                                                                                                |                                                                                                                                      | байгууламжийн тооллогын ажлыг зохион байгуулахад гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй 3027 ширхэг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болж, 1199-өөр нэмэгдсэн байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                          |     |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Гэр хорооллын бүсэд нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлнэ.<br>2025.05.01-2025.08.30 | Ариутгаж халдваргүйжүүлсэн нүхэн жорлон, бохирын цооногийн тоо, ширхэг | 2024 онд гэр хорооллын 17831 ширхэг нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлсэн | Судалгаагаар тоологдсон нийт нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллана. | Дүүргийн хэмжээнд тооллогын ажлыг зохион байгуулахад гэр хорооллын айл өрхийн нийт 10,380 нүхэн жорлон, 4959 бохирын цооног тоологдсон.<br>Дүүргийн Засаг даргын 2025 оны А/299 дүгээр захирамжийн дагуу гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, бохирын цооногыг ариутгаж халдваргүйжүүлэх ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулахаар ажлын даалгаврыг боловсруулан Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн.<br>Шалгарсан гүйцэтгэгч "Түвшибилэг төгөлдөр" ХХК, "Баяндэмбэрэл" ХХК-ийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажилд хяналт тавин 10,380 нүхэн жорлон, 4959 бохирын цооногийг бүрэн | 2025.05.01<br>2025.08.30 | 100 |

|    |                                                                                                                                                                                                                                          |                                       |                                                   |                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                  |            |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------------------------------|-------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|------------|
|    |                                                                                                                                                                                                                                          |                                       |                                                   |                                                             | ариутгуулж,<br>халдваргүйжүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                  |            |
| 3. | <p>Арга хэмжээ 1.3.<br/>Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахивар хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр нөлөөллийн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.<br/>2025.01.02-2025.12.01</p> | <p>Зохион байгуулсан сургалт, тоо</p> | <p>3 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> | <p>2-оос доошгүй сургалт арга хэмжээг зохион байгуулна.</p> | <p>Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах "Ти Эм Эл" ХХК дахин боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллах талаар дүүргийн 25 хороод, СӨХ-той хамтарсан уулзалтыг зохион байгуулж, 240 СӨХ хуванцар хаягдлаа нийлүүлж, дахин боловсруулж байна.<br/>"Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ-тай хамтран 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр иргэд, хороодын зохион байгуулагчид, сууц өмчлөгчдийн холбоодын төлөөлөлд зориулан хог хаягдлын менежмент болон хог хаягдлын чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг олгох, чадавхжуулах сургалт зохион байгуулж 200 гаруй хүнийг хамруулсан.<br/>Мөн тус байгууллагатай хамтран дүүргийн хэмжээнд хог хаягдлын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хийж, үр дүн болон цаашид хог ангилан ялгах чиглэлээр авч хэрэгжүүлэх шаардлагатай арга</p> | <p>2025.01.02<br/>2025.12.01</p> | <p>100</p> |

|    |                                                                                                                                                          |                                    |                                                                                                        |                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                          |     |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|
|    |                                                                                                                                                          |                                    |                                                                                                        |                                                                                                   | хэмжээний талаар хог тээврийн байгууллагууд болон хороодын албан хаагчдад танилцуулж ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                          |     |
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Хог хаягдлын хураамж төлөлт, хог тээврийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин, цахим мэдээллийн санг хөтөлнө.<br>2025.01.02-2025.12.01 | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | Хог тээврийн гэрээ, хог хаягдлын хураамж төлөлтөд хяналт тавих цахим мэдээллийн санг 2 удаа шинэчилсэн | Цахим мэдээллийн санд оруулсан гэрээ, төлөлтөд хяналт тавьж, мэдээллийг сар бүр шинэчилсэн байна. | Дүүргийн нутаг дэвсгэрт энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үүрэг бүхий 4 ОНӨААТҮГ нь ДИТХ-н 12 дугаар тогтоолын дагуу 2025 оны 02 дугаар сараас эхлэн нийт 650 ААНБ-тай хог тээврийн гэрээг тарифын дагуу шинэчлэн байгуулсан байна. Гэрээний мэдээллийг дүүрэг, хог тээвэр, хороод, Татварын хэлтсийн дундын мэдээллийн санд оруулж, хяналт тавин ажиллаж байна.<br><br>Дүүргийн хог тээврийн 4 ОНӨААТҮГ нь 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 173,577.424 тонн хог хаягдлыг 41,406 рейсээр тээвэрлэсэн ба гүйцэтгэлд хяналт тавьж, зардлыг ДИТХ-н 12 дугаар тогтоолоор баталсан тарифын дагуу тооцон 20.3 тэрбум төгрөгний санхүүжилтийг олгосон. | 2025.01.02<br>2025.12.01 | 100 |

|                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                     |                                                  |                                                                                             |                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                            |                          |     |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|
| 5.                                                                                                                                                                       | Арга хэмжээ 1.5.<br>Хог төвлөрүүлэх цэгийн өргөж буулгадаг хогийн сав, хог буулгаж ачих крантай автомашинаар парк шинэчлэлт хийнэ.<br>2025.01.02-2025.12.01                                                                                         | Хогийн савны тоо                                 | -                                                                                           | Шаардлагатай байршилд хогийн савыг байршуулж, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулна. | Дүүргийн төсвийн 1 тэрбум төгрөгөөр өөр дээрээ хогны бункер татаж ачдаг, өөрөө буулгах зориулалттай авто машин 2 ширхэг, хог төвлөрүүлэх сав 25 ширхэгийг худалдан авахаар техникийн тодорхойлолтыг боловсруулан дүүргийн ХАА-нд хүргүүлсэн. Гүйцэтгэгчээр "Мөнх-Инспайринг" ХХК шалгарч, нийлүүлэх шатанд хэрэгжиж байна. | 2025.01.02<br>2025.12.01 | 100 |
|                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                     | Автомашины тоо                                   | 18                                                                                          | Хог тээврийн байгууллагуудад крантай автомашинаар парк шинэчлэлт хийсэн байна.           |                                                                                                                                                                                                                                                                                                                            | 2025.01.02<br>2025.12.01 | 100 |
| Зорилт 2: Байгаль орчин, ой, усны талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, ажлын явц, үр дүнд хяналт тавих, тайлагнах. |                                                                                                                                                                                                                                                     |                                                  |                                                                                             |                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                            |                          |     |
| 6.                                                                                                                                                                       | Арга хэмжээ 1.6.<br>Нийслэлийн байгаль орчны газрын дүгнэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргын захирамжаар "Ус ашиглах зөвшөөрөл"-ийг олгож, гэрээ байгуулан, хяналт тавьж, дүүргийн Татварын хэлтэст мэдээллийг хүргүүлнэ.<br>2025.01.02-2025.12.01 | Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо | Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн 5 ААНБ-д ус ашиглах зөвшөөрөл олгосон.     | Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгож ажиллана.                                 | Нийслэлийн байгаль орчны газрын ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн "Батшил" ХХК, "Багро" ХХК, "Батшил" ХХК, "Просперити ресурсес" ХХК, "Би си эм эм" ХХК-ийн гэрээг шинэчлэн байгуулж, зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай сунгаж, "Яармаг" ХХК-д ус ашиглах зөвшөөрлийг шинээр олгосон.                                        | 2025.01.02<br>2025.12.01 | 100 |
| 7.                                                                                                                                                                       | Арга хэмжээ 1.7.<br>Туул голын сав газрын дүгнэлтийг үндэслэн "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл"-ийг дүүргийн Засаг даргын захирамжаар                                                                                                          | Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо | Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн 5 ААНБ-д ус хаях зөвшөөрөл олгож, олгосон. | Хаягдал усны дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгож ажиллана.                               | Туул голын сав газрын дүгнэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргын А/199 дүгээр захирамжаар "Эм Си Эс интернэшнл" ХХК-д хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, гэрээ                                                                                                                                                                | 2025.01.02<br>2025.12.01 | 100 |

|    |                                                                                                                                                                                                               |                                                           |                                                                                                               |                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                   |                          |     |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|
|    | олгож олгох гэрээ байгуулж, хяналт тавьж, дүүргийн Татварын хэлтэст мэдээллийг хүргүүлнэ.<br>2025.01.02-2025.12.01                                                                                            |                                                           |                                                                                                               |                                                                                                          | байгуулсан. "Батшил" ХХК, "Багро" ХХК, "Просперити ресурсес" ХХК-н гэрээг шинэчлэн байгуулж, зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай сунгасан.                                                                                                                                                            |                          |     |
| 8. | Арга хэмжээ 1.8. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.<br>2025.03.01-2025.12.01 | Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо, хэрэгжилтийн хувь | 5                                                                                                             | 3                                                                                                        | Дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй 32 аж ахуйн нэгжээс 2025 онд үйл ажиллагаа явуулж байгаа 19 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 3 удаагийн хяналт шалгалтыг явуулж, байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажилласан. | 2025.03.01<br>2025.12.01 | 100 |
|    |                                                                                                                                                                                                               | Нөхөн сэргээлт хийсэн талбай, га                          | 10 га газарт техникийн нөхөн сэргээлт, 5,4 га газарт биологийн нөхөн сэргээлт хийлгэн хяналт тавьж ажилласан. | 10 га-аас доошгүй газарт техникийн нөхөн сэргээлт, болон биологийн нөхөн сэргээлт хийлгэн хяналт тавина. | НБОГ-ын даргын А/149 дүгээр тушаалаар 2025 оны нөхөн сэргээлтийг хянаж хүлээн авах ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл дүүргийн хэмжээнд нөхөн сэргээлтийг хүлээн авахаар бэлтгэл ажил хангаж байна.                                            | 2025.05.01<br>2025.12.01 | -   |
| 9. | Арга хэмжээ 1.9. Дүүргийн зуслан ногоон бүс буюу 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэрт байгаа булгын эхийг хашиж хамгаалах ажлыг зохион байгуулна.<br>2025.05.01-2025.12.01                               | Тохижуулсан булгын тоо                                    | Дүүргийн 12 дугаар хороо, Ар булгын эхийг хашиж, хамгаалсан.                                                  | 1-ээс доошгүй булгын эхийг хашиж хамгаалсан байна.                                                       | Дүүргийн хэмжээнд 2 булаг, рашааны эх үүсвэрийг хашиж, хамгаалах ажлыг ААНБ-уудтай хамтран зохион байгуулсан. Үүнд: 1.12 дугаар хороо, "Хайрханы Ундарга булаг"-ийн эхийг "Баран групп"                                                                                                           | 2025.05.01<br>2025.12.01 | 100 |

|  |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |  |  |
|--|--|--|--|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
|  |  |  |  |  | <p>ХХК дүүргийн нутаг дэвсгэрт "Ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр" төслийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хүрээнд тохижуулсан.</p> <p>2. 14 дүгээр хороо, "Гавьжийн шандын булаг"-н эхийг "Бор зам" ХХК, "Өгөөмөр гоулд" ХХК, "Суурь хана" ХХК, "Просперити ресурсес" ХХК, "Кастло петро майнинг" ХХК, "Уянхайрхан" ХХК, "Өвөрхарзат" ХХК, "БИ СИ Эм ЭМ" ХХК, "Ядам-Од" ХХК, "Очирням" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хүрээнд тохижуулсан.</p> |  |  |
|--|--|--|--|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|

**Стратеги төлөвлөгөөний зорилго 6. "Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна."**

**Зорилт 3: Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.**

|     |                                                                                                                                                                                                                      |                       |                                                                                                          |                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                     |                                  |     |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|-----|
| 10. | <p>Арга хэмжээ 1.10.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжих төсөл, үйл ажиллагаанд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хүсэлтийг судалж,</p> | Хүргүүлсэн санал, тоо | <p>157 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг судалж, холбогдох байгууллагад санал хүргүүлсэн.</p> | <p>Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд санал авахаар ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг бүрэн судалж, шийдвэрлэнэ.</p> | <p>Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх ажилд Засаг даргын санал авах хүсэлт ирүүлсэн 234 иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийн дагуу төсөл арга хэмжээний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, газрын зөрчлийг судалж,</p> | <p>2025.01.02<br/>2025.12.01</p> | 100 |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|-----|

|     |                                                                                                                                                                                         |                                    |                                                                                                         |                                                                                                        |                                                                                                                                                                                                                 |                          |     |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|
|     | холбогдох шатны байгууллагуудад санал хүргүүлнэ.<br>2025.01.02-2025.12.01                                                                                                               |                                    |                                                                                                         |                                                                                                        | БОУАӨЯ, НБОГ-т албан бичгээр санал хүргүүлсэн.                                                                                                                                                                  |                          |     |
| 11. | Арга хэмжээ 1.11.<br>Усны тоо бүртгэлийг зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна.<br>2025.01.02-2025.12.01                                                                  | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1<br>(Усны тооллого, ус ашиглах, хаягдал ус хаях зөвшөөрөл)                                             | 1                                                                                                      | Дүүргийн хэмжээнд усны тоо бүртгэлийг 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн боловч НБОГ-с нийслэлийн хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөсөн тул тооллогын ажлыг хойшлуулсан. | 2025.01.02<br>2025.12.01 | -   |
